




АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- ☒ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- ☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

Барилга, хот байгуулалтын яам

Бодлого, төлөвлөлтийн газрын Гадаад хамтын ажиллагааны хэлтэс /Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 10 дугаар сарын 14-ны өдрийн 340 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулав/

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Гадаад төсөл, хөтөлбөр, хамтын ажиллагаа хариуцсан шинжээч Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 10 дугаар сарын 14-ны өдрийн 340 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулав/

Ахлах түшмэл, ТЗ-9

Ажлын цаг:

Ажлын байрны албан ёсны байршил:

Ажлын өдөр 8 цаг

15170, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Барилгачдын талбай 3, Засгийн газрын XII байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

Хэвийн

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Салбарын хоёр болон олон талт гадаад хамтын ажиллагааны оновчтой бодлого, төсөл, хөтөлбөрийг салбарын бодлого, үйл ажиллагааны стратегитай уялдуулан тодорхойлж, салбарын болон яамны гадаад харилцаа, төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагааг нэгдсэн зохицуулалтаар хангаж, төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтыг татах, шийдвэрлүүлэх чиг үүргийн хүрээнд гүйцэтгэлийн үр дүнг газрын даргын өмнө хариуцна. Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 10 дугаар сарын 14-ны өдрийн 340 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулав/

Албан тушаалын зорилт:

- 1.Салбарын гадаадын улс орон, байгууллагатай хоёр болон олон талт хамтын ажиллагааны мэдээллүүдийг нэгтгэн боловсруулж хамтын ажиллагааны чиглэл, боломжийн судалгааг хийж мэдээллийн бааз бий болгох;
- 2.Гадаадын зээл, тусламжийн эх үүсвэрийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээний саналыг салбарын бодлогод нийцүүлэн нэгтгэж, хөрөнгийн эх үүсвэрийг тодорхойлж, нэг цонхны бодлоготой уялдуулан холбогдох яамтай хамтран шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах;
- 3.Салбарын гадаад хамтын ажиллагаа, гадаадын төсөл, хөтөлбөрийн чиглэлээр хэрэгжүүлэх ажлын хоорондын уялдааг хангах ажлыг хариуцаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;
- 4.Засгийн газрын хуралдаанаар салбарын гадаад хамтын ажиллагаа, төсөл, хөтөлбөр, сайдын гадаад улсад хийх айлчлалын чиглэлээр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулж, тэмдэглэл, тогтоол болон бусад шийдвэрийг гаргуулах, биелэлтийг тайлагнах;
- 5.Хууль тогтоомжоор олгосон бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Гадаадын улс орон, байгууллагатай хоёр болон олон талт хамтын ажиллагааны хүрээнд үйл ажиллагаа явуулах зорилгоор хийгдсэн хурал, уулзалтуудын мэдээллийг тус бүрээр нэгтгэн боловсруулах, цаашдын хамтын ажиллагааны чиглэлийг тодорхойлох;	Гадаад хамтын ажиллагааны чиглэл тодорхойлогдсон байна.	Г, Х
	2.Гадаадын улс орон, байгууллагатай хоёр болон олон талт байгууллага тус бүрийн хамтын ажиллагааны лавлахыг боловсруулах, цаашдын арга хэмжээг төлөвлөх, санал боловсруулах;	Боловсруулалт зохих шаардлагыг хангасан байна.	Г, Х
2 дугаар зорилтын хүрээнд	1.Гадаадын зээл, тусламжийн боломжит эх үүсвэрийг тодорхойлж, холбогдох газар, хэлтсээс бодлогын түвшинд санал болгосон төсөл хөтөлбөрийн саналыг холбогдох байгууллагад хүргүүлж, хэрэгжүүлэх шийдвэрийн түвшний гэрээ, хэлэлцээр байгуулах шат хүртэлх ажлыг яамны хэмжээнд нэгдсэн байдлаар зохион байгуулж, шийдвэрлүүлэх;	Гадаадын зээл, тусламжийн эх үүсвэрийг тодорхойлж, төсөл хэрэгжүүлэх шийдвэр гаргуулсан байна. Санхүүжилтийн гэрээ, хэлэлцээр байгуулахад дэмжлэг үзүүлсэн байна.	Г, Х



	2.Салбарын гадаад төсөл, хөтөлбөрийн ажлыг урагшлуулах асуудлыг Засгийн газар хооронд болон дээд, өндөр түвшний арга хэмжээ, айлчлал, уулзалт, хуралдааны удирдамж, яриа хэлэлцээний сэдэв, гадаад хамтын ажиллагааны төлөвлөгөөнд тусгуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг тайлагнах;	Санал бэлтгэж, холбогдох байгууллагад хүргүүлсэн байна. Гадаад хамтын ажиллагааны төлөвлөгөөнд тусгуулсан байна.	Г, Х
	3.Гадаадын зээл, тусламжаар хэрэгжсэн төслийн мэдээллийг нэгтгэж, холбогдох төсөлд дүн шинжилгээ хийх, төслийг хөгжүүлэх, өргөжүүлэх, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх замаар үргэлжлүүлэн хэрэгжүүлэх боломжийг судалж, тайлагнах, шийдвэрийг хангуулах ажлыг зохион байгуулах.	Хэрэгжсэн төсөл, хөтөлбөрийн мэдээллийг нэгтгэж, хэрэгжилтэд дүн шинжилгээг хийж, холбогдох шийдвэрийг гаргуулсан байна.	Г, Х
3 дугаар зорилтын хүрээнд	1.Яам, харьяа байгууллагуудын гадаад арга хэмжээний төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийг боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулах чиглэлээр холбогдох талуудтай хамтран ажиллах;	Төлөвлөгөөг батлуулж хэрэгжилтийг хангуулсан байна.	Х, Г
	2.Монгол Улсын Засгийн газрын аливаа олон улсын гэрээ, хэлэлцээрээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх, шийдвэрлүүлэх, мөрдүүлэхэд хяналт тавьж ажиллах;	Олон улсын гэрээ хэлэлцээрээр хүлээсэн үүргийн хэрэгжилт хангагдсан байна.	Х, Г
	3.Яамны удирдлагын урилгаар гадаадын төлөөлөгчдийн Монгол Улсад хийх айлчлалыг зохион байгуулах, хүлээн авахтай холбоотой ажлуудад дэмжлэг үзүүлэх;	Үр дүнг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажилласан байна.	Г, Х
	4.Гадаадын болон олон улсын байгууллагуудтай харилцах, хамтын ажиллагаа өрнүүлэх ажлыг нэгдсэн зохион байгуулалтаар хангаж, мэргэжлийн арга зүйн зөвлөгөө өгч, харилцааны түвшинд шийдвэр гаргаж ажиллах.	Нэг цонхны бодлогыг баримталж ажилласан байна.	Х, Г, Ш
	5.Гадаадын болон олон улсын байгууллагуудтай хийсэн яриа, хэлэлцээ, төсөл арга хэмжээ, гэрээ, санамж бичиг зэрэг мэдээллийг нэгтгэн холбогдох байгууллага, албан хаагчийг мэдээллээр хангах.	Яриа, хэлэлцээний сэдэв, төлөвлөгөөнд тусгуулсан ажлуудыг хэрэгжүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлсэн байна.	Х, Г
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Засгийн газрын хуралдаанд салбарын гадаад хамтын ажиллагаа, төсөл, хөтөлбөрийг шийдвэрлүүлэх чиглэлээр танилцуулах мэдээ, мэдээллийг холбогдох дүрэм журмын дагуу	Шаардлагатай мэдээллийг холбогдох журмын дагуу шийдвэрлүүлж, биелэлтийг хангаж	Х, Г



	боловсруулж, гарсан тэмдэглэл, тогтоол, бусад шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, тайлагнах;	ажилласан байна.	
	2.Засгийн газрын гишүүний гадаад хийх айлчлалын удирдамж, яриа хэлэлцээний сэдэв, тушаал шийдвэрийн төслийг холбогдох журмын дагуу боловсруулж, Засгийн газрын ээлжит хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнах;	Шаардлагатай мэдээллийг холбогдох журмын дагуу шийдвэрлүүлж, биелэлтийг хангаж ажилласан байна.	Х, Г
	3.Салбарын гадаад хамтын ажиллагаа, төсөл хөтөлбөрийн нэгдсэн уялдааг хангах журмын төсөл боловсруулах, батлагдсан журамд хяналт тавьж, удирдлагуудад тайлагнаж ажиллах;	Батлагдсан дүрэм, журамд хяналт тавьж, биелэлтийг хангуулж ажилласан байна.	Х, Г
	4.Эрхэлсэн асуудлын чиглэлээр УИХ, Засгийн газрын тогтоол, шийдвэр, Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг нэгтгэж, тайлагнах;	Өгөгдсөн үүрэг даалгавар хэрэгжсэн байна. Тайлан үнэн бодит, боловсруулалтын шаардлага хангасан байна.	Г
	5.Гадаад томилолт, уулзалтыг тогтмол бүртгэн ажлын хэрэгцээнд ашиглах, холбогдох байгууллага, нэгжийг мэдээллээр хангах.	Бүртгэл тогтмол хийгдэж, мэдээллээр хангагдсан байна. Залгамж чанарыг баримталсан байна.	Х, Г
5 дугаар зорилтын хүрээнд	1.Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд сахих, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах;	Холбогдох хууль тогтоомжийг баримталж ажилласан байна.	Г
	2.Албан тушаалын тодорхойлолтод тусгагдаагүй боловч цаг үеийн ажлын зайлшгүй шаардлагаар удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг шуурхай гүйцэтгэх;	Цаг хугацаанд хийж гүйцэтгэсэн байна.	Г
	3.Удирдлагыг өөрийн эрхэлсэн асуудлын чиглэлээр шаардлагатай мэдээллээр хангаж, түүний ажилд мэргэжил, арга зүй, техник зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх.	Бүх талын дэмжлэг үзүүлж ажилласан байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	- Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.
Мэргэжил	- Олон улсын харилцаа /031202/; - гадаад хэл, орон судлал /023102/; - эдийн засагч /0311/; - яамны үндсэн чиг үүрэгт хамаарах үйл ажиллагааны чиглэлийн мэргэжлийн инженер.
Мэргэшил	- Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх.



Туршлага		- Төрийн албанд 8 жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх.
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	- судалгааны арга зүй эзэмшсэн байх; - мэдээлэлд тулгуурлан бүтэц чиг үүргийн шинжилгээ хийх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх; - байгууллагын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг илрүүлэх; - судалгааны үр дүнг харьцуулан үнэлэх, тайлбарлах; - нарийн төвөгтэй мэдээллийг шинжилж, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тодруулах; - мэдээллийн үнэн, бодит байдлыг шалган нягтлах; - бусад.
	Асуудал шийдвэрлэх	- Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчлэх; - өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах; - асуудал шийдвэрлэх эдийн засаг, хууль зүйн үндэслэлийг тодорхойлох; - шаардлагатай асуудлаар судалгаа хийж, дүнг хариуцах; - хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө өгөх мэдлэг, чадвартай байх; - асуудлын шийдэлд шинэлэг байдлыг нэвтрүүлдэг байх; - бусад.
	Багаар ажиллах	- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах; - бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох; - ёс зүйн хэм хэмжээг сахиж, зарчимч, тууштай, ажил хэрэгч байж, бусдыг дэмжих; - шинэлэг санаа, үйлчилгээг нэвтрүүлэх, шинэ санаачилга, бүтээлч үйл хандлагыг нэвтрүүлэх; - хувийн зохион байгуулалт, ажлын цаг ашиглалт сайтай байх; - бусад.
	Бусад	- албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах; - компьютерийн хэрэглээний программ, мэдээллийн технологи ашиглах; - англи хэл эсхүл бусад гадаад хэлийг ахисан төвшнөөс доошгүй төвшинд эзэмшиж, эх сурвалжаас мэдээлэл ашиглах, боловсруулах чадвартай байх; - жендерийн эрх тэгш байдлыг хангах; - авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх; - монгол бичгээр уншиж, бичих чадвартай байх.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:


- Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Бусад харилцах субъект:

- УИХ, ЗГХЭГ, ЕТГ болон УИХ, ЗГ-ын харьяа төрийн захиргааны байгууллагууд;
- Яам, агентлаг, нутгийн захиргааны болон бусад төрийн байгууллагууд;
- Төрийн бус байгууллагууд;



	- Олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрүүд; - Иргэн, хуулийн этгээд.
V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ	
<u>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</u>	<u>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</u>
<u>Албан тушаал:</u> АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ, ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА  Д. БАЯРСАЙХАН (Гарын үсэг) 2020 оны 10 дугаар сарын 14 -ны өдөр	<u>Байгууллагын нэр:</u> ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ <u>Шийдвэрийн огноо:</u> 20 10 14 <u>Дугаар:</u> 340
Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:	
<u>Байгууллагын нэр:</u> БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ <u>Шийдвэрийн огноо:</u> <u>Дугаар:</u> (тамга/тэмдэг) ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  С. МАГНАЙСҮРЭН (Гарын үсэг) 2020 оны 10 дугаар сарын 16 -ны өдөр	

